

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-9
<i>1. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	4-9

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
11 дүгээр сарын 28-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 23 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, А.Ганбаатар, Ч.Номин, Б.Хэрлэн, О.Цогтгэрэл;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Л.Гантөмөр, Л.Оюун-Эрдэнэ, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Г.Уянгахишиг, Ө.Шижир, Л.Энх-Амгалан.

Нэг.Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Л.Өлзийсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Барсүрэнгийн Баасандоржийг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 11 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 23 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Жадамбын Бат-Эрдэнэ, Жигжидийн Батжаргал, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Цэрэнпилийн Даваасүрэн, Тогмидын Доржханд, Сархадын Зулпхар, Цагаанхүүгийн Идэрбат, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Лхагваагийн Мөнхбаатар, Нямтайширын Номтойбаяр, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хуралдаандаа ирсэн 53,1 хувьтай байна.

Одоо Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудал хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйл Улсын Их Хурлын даргын бүрэн эрх.

13.1.18.Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх санал гаргаж, Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх

47 дугаар зүйл Ерөнхий нарийн бичгийн дарга.

47.2.Ерөнхий нарийн бичгийн дарга Хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө. Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулах журам Ерөнхий нарийн бичгийн даргыг томилоход хамаарахгүй. Ийм учраас Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох саналыг Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал даргын микрофоныг өгье

Н.Учрал: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт Ерөнхий нарийн бичгийн дарга Хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх бөгөөд Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилуулахаар санал болгож байна.

Лувсандоржийн Өлзийсайхан нь 1998 онд Монгол улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Магистр зэрэгтэй. 2021 онд Парламентын хуралдааны дэг, эрх зүйн харьцуулсан шинжилгээ бүтээлээр Хууль зүйн ухааны докторын зэргийг хамгаалсан. 2025 онд Швейцарын Холбооны Улсын Берний их сургуульд зочин судлаачаар ажилласан. Профессор цолтой. Монгол Улсын гавьяат хуульч. 1998-2002 онд Монгол Улсын Багшийн Их сургуульд багш, 2002-2016 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, ахлах багш, 2007-2012 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүй хууль, тогтоомжийн хэлтэст зөвлөх, ахлах зөвлөх, 2012 онд Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх, 2013-2015 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, 2015-2017 онд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шүүгч, 2017-2018 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх, 2018-2019 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын дарга, 2019 онд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, 2019-2023 онд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдон ажилласан байна.

Лувсандоржийн Өлзийсайхан МУИС-ийн Хууль зүйн сургуульд 17 жил багш, Эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй, парламентын судлалын чиглэлээр 10 гаруй 1 сэдэвт бүтээл, ном, гарын авлага туурвиж, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, судалгааны ажил бичиж, эрдэмтэн судлаачид болон олон нийтийн хүртээл болгожээ.

Үндсэн хуулийн хяналт, шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох үйл ажиллагааны практикийг судлах чиглэлээр АНУ, ОХУ, ХБНГУ, Япон, Франц, БНСУ Швейцарын Холбооны Улсад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Лувсандоржийн Өлзийсайхан нь дэлхий дахины болон Монголын парламентын түүх, сорилт бэрхшээл, парламентат ёсны, ирээдүйн хөгжлийн асуудлаар олон тооны судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, үр дүнг нь Улсын Их Хурлын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн, төрд бэлтгэгдсэн мэргэшсэн хуульч юм.

Л.Өлзийсайхан нь 2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцад Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан оролцож, Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж, хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулсан. Тодруулбал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу парламентын эрх зүйн орчны болон бусад шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монголд парламентын ардчиллыг бэхжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж ирсэн бөгөөд энэхүү мэдлэг, ур чадвар, туршлага нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амьдралд бодитой хэрэгжүүлэх, үр нөлөөг сайжруулах асуудалд чухлаар тавигдаж байгаа энэ цаг үед онцгой ач холбогдолтой гэж Их Хурлын даргын хувиар үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тавигдах хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх гэсэн үндсэн шаардлагыг хангаж байгаа нь хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаанаас эхлэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт болон Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиглэлээр 27 жил ажилласан туршлагатай Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн албан тушаалд томилох саналыг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Танилцуулга хийж дууслаа.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт, үг тусдаа юм байна. Байхгүй юу. Ариунзаяа гишүүнээр тасаллаа.

А.Ариунзаяа: Чөлөөлөх нь хамтдаа юм байна гэж ойлгож байгаа. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Улсын Их Хурлын дэгийн зөвлөх бөгөөд Тамгын газрын дарга, төрийн захиргааны албан тушаалтан байна гэж заасан байгаа. Тэгэхээр төрийн захиргааны албан тушаалын томилгоог бид нар ярьж байгаа. Ер нь гэхдээ энэ бол улс төрийн томилгоо болоод байгаа гэдгийг бид нар бас үгүйсгэх боломжгүй. Тэгээд би энэ ташрамд юу хэлэх гээд байна вэ гэхээр Баасандорж дарга болон Улсын Их Хурлын тамгын газар, Тамгын газрын ажилтнууд, зөвлөхүүд, ахлахууд бүхий л ажилтнуудад ямар нэгэн буруу байхгүй. Тэгэхээр улс төрчид өөрсдийнхөө алдааг, улс төрийн шийдвэрийг төрийн захиргааны албан хаагчдадаа нялзааж огтоос болохгүй. Ярилцлага өгөхдөө л Баасандоржийн буруу мэтээр зарим улс төрч ярилцлага өгөөд байна лээ. Үгүй шүү дээ. Баасандорж болон Улсын Их Хурлын Тамгын газар цаасан дээр бичигдсэн байгаа хуулийнхаа дагуу л зөвлөмжүүдээ өгсөн, үйл ажиллагаагаа явуулсан, зохион байгуулсан. Улс төрийн агуулгаар ямар нэгэн өөр шийдвэрүүд гарсан байгаа бол энэ улс төрчдийн л алдаа, улс төрчдийн л бодлого болохоос биш яг захиргааны албан тушаалтнуудын алдаа биш ээ. Ийм учраас Баасандоржийг ч гэсэн чөлөөлж байгаа нь эргүүлээд насан туршид нь хохироох үйлдлийг бүү гаргаасай. Баасандорж төрд бэлтгэгдсэн маш сайн хуульч, маш сайн залуу шүү. Баасандоржид ямар нэгэн буруу байхгүй гэдгийг бас протоколд үлдээх, эргүүлээд шийдвэр гаргаж байгаа хүмүүст ч гэсэн захиж хэлмээр байна. Энэ залуучуудыг битгий хохироогоорой. Улс төрчдийн тоглоом дунд хохирогч болох ёсгүй шүү гэдгийг бас сануулж хэлмээр байна.

Тэгээд Өлзийсайхан даргад бол бас бас амжилт хүсье. Бид нар хамтарч ажиллаж байсан. Цаашдаа ч гэсэн маш сайн ажиллана гэдэгт итгэлтэй байна. Залуучуудыг битгий хохироогоорой гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Асуулт асууж дууслаа. Одоо Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Батжаргал гишүүнээр тасаллаа. Зулпхар гишүүн үгээ хэлье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын дарга өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд Их Хурлын Тамгын газрын даргыг хэнийг сонгож, хэнийг томилуулахаа бол өөрөө санал болгож байна. Энийг бол бид дэмжээд явах нь зөв гэж үзэж байгаа юм.

Сая Их Хурлын дарга өөрөө ч гэсэн танилцуулга дээрээ их тодорхой хэлж байна. Төрийн ажлын туршлагатай, хууль, эрх зүйн өндөр мэдлэгтэй. Парламент ёсонд бас мэргэшсэн, төлөвшсөн ийм хүнийг дэвшүүлж байгаа гэж. Нөгөөтээгүүр

бидний ойлгосноор бол чадавхын зарчмаар гэж бид хэлж байгаа юм. Мерит зарчим гэдэг бол чадавхын зарчим гэсэн үг. Төрийн албанд бүхий л шатанд нь ажиллахдаа тухайн албыг бүрэн мэдлэг чадвар, тэрнээс гадна өөрийнхөө хариуцлагаар хашсан ийм албан тушаалтан учраас би итгэж энэ хүнийг санал болгож байна гэж байна. Энийг нь бол бид хүлээж авах ёстой.

Нөгөөтээгүүр Өлзийсайхан дарга бол урьд нь бас Улсын Их Хурлын Тамгын даргаар ажиллаж байсан. Тухайн үедээ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийх ажлыг бас хамтран гардсан хүмүүсийн 1 гэж ойлгож байгаа. Өөрөө парламентын чиглэлээр мэргэшсэн судлаач. Тэрнээс гадна практик дээр энэ ажлаар бүрэн мэргэшсэн учраас тохирно гэдэгт бол эргэлзэх зүйл байхгүй.

Нөгөөтээгүүр бас 3 дахь зүйлийг заавал хэлэх ёстой. Түрүүн бас Улсын Их Хурлын дарга ч гэсэн тэмдэглэсэн. Ер нь Их Хурлын Тамгын газрын манай дарга ч бай, зөвлөхүүд ч бай, тэрнээс гадна манай референтүүд ч бай Их Хурлын гишүүдийг алдаа хийж байгаа бол алдааг нь зогсоох үүрэгтэй. Энэ бол ямар нэгэн байдлаар дур зоргын асуудал гарах гэж байгаа бол, эсвэл санамсаргүйгээр, мэдэхгүйгээр гарах гэж байгаа алдаа байгаа бол энийг засаж залруулах нь өөрөө төрийн ажил талаасаа маш чухал. Тэгж байж бид бас төрийн албан хаагчдынхаа, ялангуяа Улсын Их Хурлын гишүүдийнхээ алдаа гаргахгүйгээр ажлаа хийх бас өөрийнхөө үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх энэ баталгааг нь хангах ёстой. Тэр баталгааг хангаж чадаагүйгээс болоод ямар нэгэн асуудал үүсчхээд, дараа нь тэр нь явсаар байгаад улс төрийн бүр сүүлдээ нийгмийн шүнгэрээнд маш том эргэлзээ, тээнэгэлзээ, маргаан дагуулдаг энэ байдлаас бид нар ангижрахын тулд мэргэшсэн парламент, мэргэшсэн парламентчид, тэрнээс гадна мэргэшсэн парламентын зохион байгуулалтыг хариуцсан төрийн албан хаагчид байх энэ соёлоо бүрэн төлөвшүүлэх ёстой гэдэгт бол эргэлзэхгүй байна.

Өмнө нь ажиллаж байсан Баасандорж даргыг бол сая Ариунзаяа гишүүн бол хэлж байна. Үнэхээрийн бас мэргэшсэн хүн. Тэрэнд бол ямар ч эргэлзэх зүйл байхгүй. Агентлагийн дарга байсан, Төрийн нарийн бичгийн дарга байсан. Тэрнээс гадна хуулийн чиглэлээр бол мэргэшсэн. Гэхдээ Их Хурлын даргын өөрийнх нь шийдэл учраас бид энэ шийдэл, энэ сонголтыг нь бол хүндэтгэж дэмжих ёстой гэсэн ийм байр суурь дээр байна.

Өлзийсайхан дарга урьд нь яаж ажиллаж байсан тэр туршлага дээрээ тэрнээс гадна Үндсэн хуулийн цэц дээр ч гэсэн сая шинэ шийдвэр гарахад оролцсон тэр туршлага дээрээ тулгуурлан энэ ажлыг аваад явна гэдэгт бол эргэлзэхгүй байна.

Төгсгөлд нь бас нэг зүйл яригдаад байна л даа. Энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүн байсан хүнийг бол болиод ороод ирлээ гэж. Энэ бол хуулийн ноён оргил юм гэж. Тийм ноён оргил гэж юм бол байхгүй. Зүгээр л төрийн ажил. Төрийн ажлыг хийж байгаад өөр төрийн ажилд очих хэсэг сонголт хийх нь бол төрийн албан хаагч хүний, иргэн хүний өөрийнх нь эрхийн асуудал. Бид бол цаашдаа хэтэрхий бас ийм романтик, уянгалсан зүйл ярьдгаа болих хэрэгтэй. Хүн ямар ч ажлыг яаж сонгож хийж болно. Ямар ч хүнийг надтай ажиллаач гэж бас санал тавьж болно. Энэ 2 тал хоёулаа жишээ нь энэ санал дээр нэгдэж байгаа бол бид тэрүүгээр нь шийдвэр гаргаж сурах хэрэгтэй. Хэтэрхий романтик философи хийсээр байгаад бид нар заримдаа төрийн ажлыг бас хэтэрхий хэлбэрийн байдал руу оруулдаг шүү гэдгийг би энд зориуд хэлье. Бид прагматик байх ёстой. Бид рационал байх ёстой. Бид асуудалд бодитой ханддаг байх ёстой. Бидний үйл ажиллагаа бол цэвэр хуулийн

хүрээнд байх ёстой. Энийг хангуулж чадна гэдэгт бол бүрэн эргэлзэшгүй байна. Амжилт хүсье Өлзийсүрэн дарга аа.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Одоо Жигжидийн Батжаргал гишүүн үгээ хэлнэ.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ Монгол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь хууль дээдлэх зарчим. Хууль дээдлэх зарчмыг барихгүйгээр юм явахгүй. Хэдэн биеийгээ юу гэж ч гоёор яриад, юу гэж ч янз бүрээр муу хэлээд, асуудал шийдэгддэг юм байхгүй. Барьдаг ганцхан тов тодорхой зарчим нь хуулиа дээдлэх л ёстой. Үүнийг ер нь хаа хаанаа улс төрчид нь ч тэр, энэ улс төрчдийн үйл ажиллагааг хангуулах чиг үүрэгтэй Тамгын газар нь ч тэр бүгдээрээ энэ зарчим дээрээ л ажиллах ёстой. Тэгээд би мэргэжлийн ур чадвар талаасаа бол хууль тогтоох төрийн эрх барих дээд байгууллагад тамгыг нь түшээд, гал тогоог нь бариад явахад бол болох хүн гэж би дэмжиж байна гэдгээ зориуд хэлмээр байна.

Гэхдээ бидэнд бодох юм их байна. Энэ улс орны чинь амьдралын урагшлалт төдийлөн ахиж өгөхгүй байгаа явдал чинь төрийн бодлого хийгээд түүнийгээ хангах эрх зүйн орчин нь өөрөө яг нийцээд байгаа юм уу, үгүй юм уу. Тэгээд үүнийгээ бид 5 жил тутам хуулиудынхаа хэрэгжилт, үр дүнд үнэлгээ мониторинг хийгээд, сайжруулах барих энэ тэр гээд юмнууд байгаад байгаа юм. Энийг нь дан ганц улс төрчид хийх ёстой юм уу. Энэ мэргэшсэн баг нь хийх ёстой юм уу. Би энэ тал руугаа илүү жоохон хараасай гэж ийм юм бодох юм гэж.

2 дугаарт улс төрчид янз бүрийн санаа оноонууд гаргаж болно. Тооцоо судалгаа гэдэг юм уу, эсвэл эрх зүйн мэдлэгийн түвшин гэдэг юм уу энэ юмнуудаас хамаараад, янз бүрийн юм гарч болно. Түүнийг нь хууль зүйн техник талаасаа эрх зүйн тэр соёлын хүрсэн түвшин талаасаа зөв болгож, хууль болгож гаргах асуудал нь энэ л зөвлөн туслах чиг үүрэгтэй мэргэжлийн багт л байгаад байгаа шүү дээ. Тэгээд энэ талаасаа л илүү асуудалдаа анхаармаар байна. Тэгвэл энэ Монгол төр эндээс гарч байгаа шийдлүүд нь амьдралдаа жоохон нийцэж, ээнэгшиж, энэ улс орны хөгжилд, иргэдийн аж амьдралд наалдацтай байх болов уу гэж ингэж хараад байгаа. Тэгээд би шинээр ажил авч байгаа хүнийг энэ талаасаа илүү асуудалдаа хараасай гэдэг зүйлийг хэлмээр байна. Тэгээд өөрчлөлтүүд дагаж бужигнаан үүсээд, төрийн тогтвортой байдал гэдэг юм уу энэ тогтолцооны тогтвортой байдалд нөлөө үзүүлээд байгаа юмнууд байгаад байгаа юм. Энийгээ анхаарах ёстой.

Яг нарийндаа энэ Улсын Их Хурал дээр нэг баахан ажлын хэсэг байгуулсан явдал бол мэргэжлийн Байнгын хороодынхоо үйл явцыг жоохон сулруулчихсан шүү. Би бол тэгж хараад байдаг. Тэгээд бүгдийг нь нэг амьсгаагаар хүчингүй болгочих нь ч хаашаа юм. Энэ ажлын хэсгүүдийн чиг үүрэг, гүйцэтгэл юмнуудыг нь үнэлж үзээд, бас нэлээдгүй хугацаа өнгөрсөн. Хүмүүс тодорхой хэмжээний оюун санаа, хөдөлмөр зарцуулалт хийсэн байлгүй дээ. Тэнд гайгүй боловсруулалт юмнууд гарсан байлгүй дээ. Түүнийг нь цааш нь зөв аваад батлах, шийдэл болгох асуудлууд байвал шийдлийг нь гаргачих юм сан гэж би бодох юм. Үр дүнгүй байгаа юмнуудыг нь бол буулгах хэрэгтэй. Одоо ер нь тэгээд цаашид энэ мэргэжлийн Байнгын хороо дээрээ тулгуурладаг, үүнийхээ доор харин ажлын хэсгүүд нь ажилладаг энэ зарчмаар явахгүй бол хэвтээ бараг зэрэгцээ бүтэц бий болгож өгөөд байгаа явдал бол ер нь хариуцлагаас зугтах гэдэг юм уу эсвэл ажил явах бололцоо, боломжийг сулруулаад байгаа үйл явц шүү. Үүнийг Их Хурлын удирдлага тал ч тэр, Тамгын газар тал ч тэр онцгой анхаарлаа хандуулж ажиллах ёстой гэдгийг зориуд хэлмээр байна. Тэгээд танд ажлын амжилт хүсье.

Ц.Сандаг-Очир: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо гишүүд санал хураалтад бэлдье. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Барсүрэнгийн Баасандоржийг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 70,6 хувиар санал дэмжигдлээ.

Нэгдсэн хуралдаанд оруулах тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын тогтоол.

“Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

“Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Санал, дүгнэлтийг танилцуулахаар Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар дарга нэгдсэн чуулганд танилцуулна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Баярлалаа.

11.43 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ